



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 2/42

Эрдэнэбүлган сум

Төрийн албан хаагчдын цалинг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь хэсгүүд, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2024 оны 128 дугаар тогтоолын 3, 4, 10, 11, 12 дугаар хавсралт, 2024 оны 84 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн улс төрийн албан тушаалын цалинг нэгдүгээр хавсралтаар, төрийн захиргааны албан тушаалын цалинг хоёрдугаар хавсралтаар, төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг гуравдугаар хавсралтаар, төрийн мэргэжлийн үйлчилгээний албан тушаалын цалинг дөрөвдүгээр хавсралтаар, төрийн тусгай албан тушаалын цалинг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Хавсралтад нэр дурдагдсан албан тушаалын сарын үндсэн цалинг шинэчлэн тогтоосон хэмжээгээр тооцож 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож, олгохыг аймгийн Засаг даргын тамгын газрын ахлах нягтлан бодогч (В.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ГОМБОДОРЖ